БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2024.06.20

| д/д | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|---|---|
| Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | |
| 1 | 1.1 Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах хариуцлагыг дээшлүүлэх | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч байгаа албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын шинэчилсэн мэдүүлгийг бүртгэж баталгаажуулна. | Хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын ХАСУМ болон ХО-ын шинэчилсэн мэдүүлгийг хугацаанд гаргуулж хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Тус газрын хэмжээнд 3 албан тушаалтан ХОМ гаргадаг бөгөөд 2023 оны ХОМ-ийг 2024.01.29-нд хугацаанд нь гаргаж баталгаажуулсан. 2 албан хаагч Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх авч улсын байцаагчаар томилогдоход ХАСУМ-ийг гаргаж АТГ-аар хянуулж ашиг сонирхлын зөрчилгүй тул Нийгмийн даатгалын улсын байцаагчаар томилогдсон. |
| | | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгоно. | Шинээр томилогдсон албан тушаалтны нэр дэвшүүлсэн АТГ-ын дүгнэлтийг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байх. | Албан хаагчдын ХАСУМ болон АТГ-аас гаргасан дүгнэлтийг шилэн дансанд нээлттэй байршуулсан. |
| | 1.2 Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилох. | Шинээр албан тушаалд томилохдоо хуулийн дагуу дэвшүүлэн томилох зарчмыг баримтална. | 2024 онд шинээр албан хаагч томилогдоогүй байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.3 Авлигын эрсдлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх | Авлигын эрсдлийн үнэлгээ хийж эрсдлээс хамгаалах арга хэмжээ авна. | Авлигын эрсдлийг бууруулах арга хэмжээ авсан байх. | Авилгын эрсдэлд дүн шинжилгээ хийхэд газрын албан хаагчид сонирхлын зөрчилгүй мэдэгдэл, мөн ХАСУМ болон ХОМ гаргах зэрэг ойлголт сайн болсон бөгөөд иргэд, даатгуулагчдад авилгын хор хөнөөл, авилгыг үл тэвчих ойлголт, авилгаас хэрхэн урьдчилан сэргийлэх тухай сурталчилгааг иргэд, даатгуулагчдад сурталчлах сурталчилгааны ажилд идэвх санаачлагатай оролцдог. |
| | 1.4 Ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна. | Зөрчлийг хэлтсийн ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргасан байна. | Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй. |
| | 1.5 Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ. | Өргөдөл гомдол мэдээллийг хянан шалгаж, ёс зүйн зөвлөлөөр хэлэлцэх. | Албан тушаалтнуудад холбогдох авилга, ашиг сонирхолын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл газрын хэмжээнд илрээгүй. |
| | 1.6 Нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | Албан хаагчдад зориулсан авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулна. | Албан хаагчдын авилгын эсрэг мэдлэг, мэдээлэл сайжирсан байна. | Авилга, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд Төрийн албаны зөвлөл, дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мөн байгууллагын ЭБАТ албан хаагчдад дотооддоо 1 удаа мэдээ, мэдээлэл өгч ажилласан. |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | |
| 2 | 2.1 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримт материалыг тоон хэлбэрт шилжүүлэн цахим мэдээллийн нэгдсэн сан /цахим архив/-ыг үүсгэнэ | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг цахимаар хүлээн авна. | Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж, цаг хугацаа хэмнэсэн байна. | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг нийт 62 ажил олгогчдоос цахимаар хүлээн авч баталгаажуулан ажилласан. |
| | 2.2 Өргөдөл, гомдол, мэдээлэл | Иргэдээс байгууллага | Эх үүсвэрийн тоог | Иргэдээс өргөдөл, гомдлыг бичгээр, цахимаар, амаар, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | өгөх ил тод нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар үр дүнг сайжруулна. | нэмэгдүүлж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулна. | утсаар, шуудангаар зэрэг авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт бичгээр хандаж ирүүлсэн өргөдлүүд байна.<br><br>Иргэд, даатгуулагчдаас нийт 7 өргөдөл хүлээн авч, холбогдох албан тушаалтнуудаар тухай бүрд нь шийдвэрлүүлсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өргөдөл, гомдлын тоо 14.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |
| | | Иргэдээс байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP симтемийн өргөдөл гомдлын цэсэнд бүртгэж шийдвэрлэлтэнд хяналт тавих | Өргөдөл гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP симтемийн өргөдөл гомдлын цэсэнд бүртгэсэн байна. | Тайлант хугацаанд иргэдээс ирүүлсэн 7 өргөдлүүдийг UB ERP системд бүртгэж ажилласан. |
| | | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлүүлж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх жишгийг тогтоолгоход анхаарч ажиллана. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд тавих хяналтыг сайжруулж хугацаа хэтрүүлэхгүй байх. | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуулийн хугацаа хэтэрсэн буюу шийдвэрлээгүй өргөдөл гомдол байхгүй. Гомдлын хариуг албан өичгээр шуудангаар, бусад өргөдлийн хариуг амаар биечлэн өгч ажилласан. Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна. |
| Гурав. Төсөв санхүү , аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | |
| 3 | 3.1 Төсөв санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх | Нийгмийн даатгалын сангийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл зарцуулалтын хариуцлагыг дээшлүүлэх | Төсвийн хөрөнгө үр ашигтай зориулалтын дагуу зарцуулагдсан байна. | Нийгмийн даатгалын сангийн зардал 4117.3 сая төгрөг батлагдсанаас 3961.9 сая төгрөгийг хуулийн дагуу даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан байна. Үйл ажиллагааны 138.4 сая төгрөгийн батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу 107.3 сая төгрөгийг зарцуулан 31.1 сая төгрөгийн хэмнэлттэй, зарцуулалтанд хяналт тавьж, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгээгүй байна. |
| | | Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, | Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд | Бүтэц орон тоо, аудитын дүгнэлт, өр авлага, нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага, үйл |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг хуулийн хугацаанд албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийт танилцах боломжоор хангах. | ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна. | ажиллагааны зардлын тоон мэдээллийг, мөн хөрөнгө зарцуулалттай холбоотой тушаал шийдвэр зэргийг хуулийн хугацаанд шилэн дансны самбар, цахим системд оруулан ажилласан. |
| | 3.2 Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | Байгууллагын 2024 оны төсвийн төсөлд байгууллагын албан хаагчдаас саналыг авч тусгах ажлыг зохион байгуулах | Төсвийг албан хаагчдаас санал авч хэлэлцүүлж саналыг тусгасан байна. | НДЕГ-ын даргын А/72 тоот тушаал, төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах журам, арга аргачлалын дагуу батлагдсан маягтаар 2025 оны төсөл, 2026-2027 онуудын төсөөллийн НДСангийн зардлыг, мөн үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг тус тус боловсруулан НДЕГ-ын БХСГ-т хүргүүлсэн. |
| | 3.3 Нийтийн албаны санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох | Байгууллагад дотоод аудит, хяналт шалгалтыг хийх, дүгнэлт, зөвлөмж өгнө. | Байгууллагад дотоод аудит, хяналт шалгалт хийгдсэн байна. | Тайлант хугацаанд газрын хэмжээнд ирсэн өргөдөл гомдол, удирдах дээд газрын тогтоол шийдвэрт хяналт шалгалтыг хийсэн.<br>Иргэд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхэд өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой өргөдлүүд зонхилж байна. Энэ нь нийгмийн даатгалын шинэ системтэй холбоотой зарим үйлчлүүлэгчийн үйлчилгээ авах асуудал шийдэгдэхгүй байсан. Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа бөгөөд дүн шинжилгээ хийхэд нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийг нэг мөр ойлгож үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж, чиглэлүүд зонхилох хувийг эзэлж байна. |
| Дөрөв. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр: | | | | |
| 4 | 4.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах , авлигыг үл тэвчих үзлийг | Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, үр дүнг | Авилгаас урьдчилан сэргийлэх, авилгын нийгмийн хор аюул, авилгыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх шторкийг үйлчилгээний танхимын дэлгэцээр иргэдэд сурталчлан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | төлөвшүүлэх зорилгоор Авилгатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт тохируулан иргэдэд сурталчлах | тооцож тайлагнасан байх | ажилладаг. |
| | 4.2 Авилгын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулсан сургалтанд хамруулах | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн бололцоонд түшиглэн хүүхэд, залууст хүргэж, үр дүнг тооцож тайлагнасан байх | Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, хамрагдсан хүүхэд залуус иргэдийн тоогоор | Авилгаас урьдчилан сэргийлэх, авилгын нийгмийн хор аюул, авилгыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх ажлыг сурталчилсан гарын авлага, палкатыг байгууллагын сурталчилгааны самбарт байршуулан, мөн үйлчилгээний танхимын дэлгэцээр дүрст бичлэгийг иргэдэд сурталчлан ажиллаж байна. |
| | 4.3 Авилгатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх. | АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайлбар хүргүүлсэн байх. | Зөрчил байхгүй. |
| | 4.4 Албан хаагчид авилгатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилга өрнүүлэх. | Авилгын эсрэг төрийн болон ТББ, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх. | Гаргасан санал санаачилгыг дэмжиж ажилласан байх. | АТГ-аас бэлтгэсэн шторкийг газрын албан ёсны Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс пейж хуудсанд, мөн зурагт хуудас, гарын авлагыг үйлчилгээний танхимын самбарт байршуулан сурталчилж ажилласан.<br>Авилгатай тэмцэх газрын АТГ-олон нийтийн цтөв пейж хуудсанд байршуулсан "Зөв зөвд шударга зөв" аянд нэгдэж байгууллагын пейж хуудсаар дамжуулан 2 удаа дагасан ба албан хаагчид шейрлэж ажилласан. |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Б.УДВАЛ

ХЯНАСАН:
ДАРГА Б.БАЯРТУЯА

5289211
9024010422
АМТ05786